



МОНГОЛ УЛС  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20 21 он 05 дугаар  
сарын 11-ны өдөр

Дугаар 11/1257

Улаанбаатар-12  
Утас: 260817  
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
Д.ГАНБАТ ТАНАА

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Уул уурхайн салбарт нүүрс тээвэрлэлтийн чиглэлээр гарсан тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн байдал болон цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариуг Танд хүргүүлж байна.

Хүлээн авч, танилцана уу.

Хавсралт: 10 хуудастай.

Монгол Улсын сайд,  
Засгийн газрын Хэрэг  
эрхлэх газрын дарга



Ц.НЯМДОРЖ

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын  
2021 оны 5 дугаар сарын 11.-ны өдрийн  
*Хү... дугаар албан бичгийн хавсралт*  
*1258*

## УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Д.ГАНБАТААС МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДАД ТАВЬСАН АСУУЛГЫН ХАРИУ

Асуулга 1. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны "Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай" 183 дугаар тогтоолын 11-т "Хилийн боомтуудыг халдварт, хамгааллын онцгой дэглэм, горимд бүрэн хүчин чадлаар ажиллуулах, Тавантолгойн бүлэг орд, Нарийнсухайтын бүлэг орд, Оюутолгойн ордын хүрээнд байгуулагдсан ариутгал, халдвартгуйжүүлэлт, хамгаалалтын аюулгүйн бүсийн үйл ажиллагаа, нөхцөл байдалтай уялдуулан Гашуунсухайт, Шивээхүрэн боомтоор тээвэрлэлт хийж байгаа жолооч нарыг шинжилгээнд бүрэн хамруулж, эдгээр боомтыг "Ногоон бүс" болгон зарлаж, тээвэрлэлтийн дараалал үүсгэхгүй байхаар зохион байгуулахыг" холбогдох сайд нарт даалгасан шийдвэр огт хэрэгжсэнгүй.

Иймд манай улсын эдийн засагт гол үүрэг гүйцэтгэдэг нүүрсний экспортын жолооч, тээвэрлэгч болон бусад ажиллагсдыг Коронавирусын эсрэг вакцинд нэн даруй хамруулах, нүүрсний экспортыг Ковид-19 цар тахлын халдвартгүй бүс болгох чиглэлд Засгийн газраас ямар арга хэмжээ авахаар төлөвлөж байгаа талаар:

**Хариулт:** Монгол Улсын Засгийн газрын 2020 оны "Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай" 183 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Монгол Улсын Шадар сайд бөгөөд Улсын Онцгой комиссын даргын 2020 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 30 дугаар, 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 39 дүгээр тушаалуудаар Өмнөговь аймгийн нутагт орших Оюутолгой, Тавантолгойн ордод үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн авто зам, Цагаан хадны гаалийн хяналтын бүс, хилийн Гашуунсухайт боомт, Нарийнсухайтын ордод үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд, Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн авто зам, хилийн Шивээхүрэн боомтод ажиллах Ажлын хэсгийг байгуулж, Коронавируст халдвартын цар тахал хүн амын дунд тархахаас урьдчилан сэргийлэх, эрсдээлийг бууруулах, халдварт, хамгааллын дэглэмийг сахиулах, боомтын аюулгүй байдлыг хангуулах талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээтэй газар дээр нь танилцаж, заавар, зөвлөмж өгч, холбогдох зохион байгуулалтыг тухай бүр гүйцэтгэсэн. Тухайлбал, Гашуунсухайт боомтоор тээвэрлэлт хийж байгаа жолооч нарыг PCR шинжилгээнд хамруулах зорилгоор ЗӨСҮТ-ийн явуулын лабораторийг ажиллуулж, тээврийн жолооч нарыг шинжилгээнд бүрэн хамруулсан.

Мен Аймгийн Засаг дарга бөгөөд Онцгой комиссын даргын 2020 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн шийдвэрээр хилийн боомтууд, нүүрс тээврийн үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагуудад Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах удирдамжийг баталж ажилласан байна.

Түүнчлэн, Ханбогд, Цогтцэций, Гурвантэс сумдуудын Засаг даргын захирамжаар сумын хэмжээнд Шинэ төрлийн коронавирусын халдвартын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах арга хэмжээг зохион байгуулах шуурхай Штабыг байгуулан ажиллаж байна.

Улаанбаатар хотоос ирэх иргэдийг Өмнеговь аймгийн Цогт-Овоо сумын постод шалгаж, асуумж авах ажлыг зохион байгуулж байгаа бол Дорноговь аймагтай хил залгаа орших Ханбогд сум орчимд хяналтын цэг гаргаж, хулгайн тээврийг таслан зогсоох арга хэмжээг авч байна.

Мөн Цагаанхадны гаалийн хяналтын бус хилийн Гашуунсухайт боомт орчимд Дотоодын цэргийн 50 албан хаагчдыг ажиллуулж, халдварт, хамгааллын дэглэмийг сахиулах арга хэмжээг авсан болно.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 183 дугаар тогтоолд заасны дагуу ашигт малтмалын экспортын голлох хилийн боомтуудад ариутгал, халдвартгүйжүүлэлтийн ажлыг тухай бүр зохион байгуулж, Гашуунсухайт, Шивээхүрэн боомтуудаар тээвэрлэлт хийж байгаа жолооч нарыг 2020 оны 11 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлэн шинжилгээнд бүрэн хамруулах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.


Мөн энэ оны 3 дугаар сарын 18-20-ны өдруүдэд Сангийн сайд БНХАУ-тай хиллэдэг ашигт малтмалын экспортын голлох хилийн боомтуудад биечлэн очиж ажилласан бөгөөд тээврийн жолооч нар болон хилийн боомтын ажилчин албан хаагчдыг Коронавируст цар тахлын эсрэг вакцинуулалтад хамруулах ажлыг эхлүүлсэн болно.

Монгол Улсын Еренхий сайдын захирамжаар байгуулсан Ажлын хэсгийн хүрээнд Гадаад харилцааны яам, Зам, тээврийн яамнаас коронавирусын эсрэг дархлаа тогтоох вакциныг татан авах ажлыг зохион байгуулж байна. Өнгөрсөн хугацаанд хүлээж авсан вакцины хэмжээ болон цаашид авах тоон мэдээллийг доорх зурагт үзүүлэв. Үүнд:

# Вакцин хүлээн авсан байдал

- 2021.04.22-ны өдрийн байдлаар нийт 850,540 тун вакцин хүлээн авсан

	Хүлээн авсан огноо	Тунгийн тоо	Тайлбар
"КОВАКС" хетэлбэрний хүрээнд	2021.03.12	14,400 тун	АстраЗенека вакцин
	2021.03.24	25,740 тун	Файзер вакцин
	2021.04.21	50,400 тун	АстраЗенека вакцин
Арилжааны шугамаар	2021.02.27	10,000 тун	ОХУ-ын Sputnik V вакцин МЭИК ХХК
	2021.04.02	300,000 тун	БНХАУ-ын Синофарм-Веросалл вакцин
Хүмүүнлэгийн шугамаар	2021.02.22	150,000 тун	БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй туслах АстраЗенека-Ковишилд вакцин
	2021.02.22	300,000 тун	БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй туслах Синофарм-Веросалл вакцин




## Вакцины нийлүүлэлт

№	Эх үүсвэр	Вакцины нэр	Хүлээн авсан тун	Хүлээн авах огноо
<b>ХАНДИВ, БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖААР АВАХ</b>				
1.	КОВАКС хетэлбэр	AstraZeneca	48,000 тун	2021 оны 4 сард
		Pfizer	102,626 тун	2021 оны 6 сард
2.	Япон Улсын Засгийн газрын 21.5 сая ам.долларын буцалтгүй туслах	Тодорхойгүй	2.6 сая тун	-
<b>НЭМЭЛТ ЭХ ҮҮСВЭР БИЙ БОЛГОХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭ</b>				
1.	Арилжааны шугамаар	Pfizer	255,060 1.12 сая тун 1.12 сая тун	2021 оны 2-р үлиралд 2021 оны 3-р үлиралд 2021 оны 4-р үлиралд
		Sinopharm Vero cells	900,000 тун 2.8 сая тун	2021.04.22-23 2021 оны 5 сард
		Sputnik V	1 сая тун	2021 оны 4, 5 сард
<b>НИЙТ</b>			<b>9.95 сая тун</b>	

## Монгол Улсын вакцинжуулалтын явцын мэдээ

/2021 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн байдлаар/



2021 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн байдлаар Гашуунсухайт боомтоор уул уурхайн бүтээгдэхүүний экспортын тээвэрлэлт гүйцэтгэдэг 4419, Шивээхүрэн боомтоор нүүрсний тээвэрлэлт гүйцэтгэдэг 1243, Хангийн боомтоор тээвэрлэлт гүйцэтгэдэг 140, Замын-Үүд боомтоор тээвэрлэлт гүйцэтгэдэг 787, нийт 6589 жолоочид Коронавирусын эсрэг дархлаажуулалтын вакцины эхний тунг хийсэн бол Гашуунсухайт боомтоор тээвэрлэлт хийж буй 2684 жолоочид вакцины 2 дахь тунг хийгээд байна. Нүүрсний тээвэрлэлтэд ажиллах жолооч нарын дийлэнх хувь нь Коронавирусын эсрэг дархлаажуулалтын вакцинд хамрагдсан. Цаашид эхний ээлжид уул уурхайн бүтээгдэхүүний экспортын тээвэрт ажиллаж буй жолооч нарыг вакцинд бүрэн хамруулах чиглэлээр анхаарч ажиллана.

Мөн уул уурхайн экспортын голлох нэрийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч уурхайнуудын 38.8 мянга гаруй ажилчдын дархлаажуулалтын вакцинжуулалтыг 5 чиглэлээр төлөвлөн, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын тушаалаар томилогдсон дархлаажуулалтын явуулын багтай хамтарч эхний 2 чиглэл болох Тавантолгой, Нарийнсухайтын бүлэг ордод үйл ажиллагаа эрхлэгч нийт 84 аж ахуйн нэгжийн 9658 уурхайчдыг вакцинд хамруулсан.

Цаашид 2020 оны 4 дүгээр сардаа багтаан хилийн Гашуунсухайт, Шивээхүрэн боомтоор уул уурхайн бүтээгдэхүүний экспорт гүйцэтгэж байгаа тээвэрчид, хариу арга хэмжээнд оролцож байгаа төрийн болон хувийн хэвшлийн албан хаагчид, Тавантолгой, Нарийнсухайтын бүлэг ордод ажиллаж байгаа уурхайчдын вакцины 2 дахь тунг хийх ажлыг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Дээрх арга хэмжээнүүдийн үр дүнд энэ оны эхний улирлын байдлаар нүүрсний экспортын биет хэмжээ 6.8 сая тоннд хүрсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 3.7 сая тонн буюу даруй 2.2 дахин нэмэгдсэн байна. Зэсийн баяжмалын экспортын биет хэмжээний хувьд өнгөрсөн оны мөн үеэс 3 хувиар буюу 9.7 мянган тонноор нэмэгдсэн байна.

Монгол Улсын Засгийн газраас Коронавируст цар тахлын үед нүүрсний уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх үүднээс Гадаад харилцааны яам, Зам, тээврийн хөгжлийн яамаар ахлуулсан Ажлын хэсэг хятадын талтай хэд хэдэн удаагийн уулзалт хийсний үр дүнд 2020 оны 08 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн Монгол, Хятадын хилийн боомтод "Ногоон гарц"-ын журмыг хэрэгжүүлж эхэлсэн.

Энэхүү журмыг хэрэгжүүлж эхэлснээр нүүрс тээврийн жолооч нар хятадын талд тусгайлан бэлтгэсэн тусгаарлалтын байранд хонож байрлаар нүүрсний экспортыг 30-40 хувь нэмэгдүүлсэн. Тухайлбал, 2020 оны эхний хагаст Гашуунсухайт боомтоор өдөрт 300-350 ачаатай автомашин гарч байсан бол "Ногоон гарц"-ын журмыг хэрэгжүүлснээр өдөрт гарах автомашины тоо 450-600 болж нэмэгдсэн, Шивээхүрэн боомтоор өдөрт ачаатай гарч байсан машины тоо 250-аас 450 хүртэл тус тус нэмэгдсэн.

БНХАУ-ын зүгээс хилээр нэвтрүүлэх автомашины тоог гэнэт өөрчилж байгаатай холбоотойгоор авто зам дээр үүсэх дарааллыг бууруулах, жолооч нарын хөдөлмөр амралтын горимыг мөрдүүлэх зорилгоор Гаалийн ерөнхий газар, "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ хамтран Өмнөговь аймгийн Хангбогд сумын нутагт орших Цагаан хадны гаалийн хяналтын бүсэд хийгдэж буй нүүрсний ачилтад зохицуулалт хийж байна. Тухайлбал, өдөрт хилээр гарсан автомашины тоотой адил хэмжээний автомашинд нүүрсний ачилт хийж байна.

Энэхүү арга хэмжээг боловсронгуй болгох зорилгоор Гаалийн ерөнхий газраас Цагаанхад дахь гаалийн хяналтын бүсэд ачилтад орох автомашины зохицуулалтад ашиглах зорилгоор тусгайлан программын хөгжүүлэлт хийж байгаа бөгөөд ингэснээр жолооч ямар хугацааны дараа ачилтад орох нь тодорхой болж, авто зам дээр очер дараалал үүсэхээс сэргийлнэ гэж тооцож байна.

Түүнчлэн, Монгол Улсын Засгийн газраас "Ногоон гарц" түр журмыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, Хятадын талд тусгайлан бэлтгэсэн газарт тээврийн жолооч нарыг хонуулах арга хэмжээг авах чиглэлээр тус улсын талд холбогдох саналыг бэлтгэн хургуулэх чиглэл баримтлан ажиллаж байна.

БНХАУ-ын талаас эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд нүүрсний татан авалтыг бууруулаад байгаатай холбогдуулан Ул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Өмнөговь аймгийн Засаг дарга болон холбогдох бусад байгууллагуудтай хамтран Гашуунсухайт, Шивээхүрэн боомтууд, Цагаанхад суурьшлын бүс, нүүрс ачиж буулгах талбайн ногоон бүсийг цаашид хэвээр хадгалах төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна.

Асуулга 2. 2021 оны эхний улирлын байдлаар Тавантолгойгоос Гашуунсухайт боомтоор нүүрс тээвэрлэж байгаа нийт 15 мянган тээврийн хэрэгслийн ердөө 10 орчим хувь нь үндэсний хөрөнгө оруулалттай компаниудын тээврийн хэрэгсэл байна. Монгол Улсаас экспортлох нүүрс, уул

урхайн бусад бүтээгдэхүүний тээвэрлэлтийг 50-аас доошгүй хувийг үндэсний тээврийн компани, консорциум-аар гүйцэтгүүлэх тухай 2015 оны Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны 10 дугаар тогтоолын хэрэгжилт хангалтгүй байгаа учир шалтгаан юунд оршиж байгаа талаар:

**Хариулт:** Монгол Улс болон БНХАУ-ын хооронд хийж буй автотээвэрлэлтийн үйл ажиллагаа Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрээр зохицуулагддаг бөгөөд уг хэлэлцээрт хэлэлцэн тохирогч талуудын эрх бүхий байгууллагуудын хооронд тохирсон маршрутаар Монгол Улсад, эсхүл БНХАУ-д бүртгэлтэй автомашинаар тээвэрлэлт гүйцэтгэхээр заасан. Уг хэлэлцээрийн дагуу БНХАУ-д бүртгэлтэй тээвэрлэгч өөрийн тээврийн хэрэгслээр нүүрсний тээвэрлэлт гүйцэтгэх боломжтой юм.

Гэхдээ Монгол Улсын Засгийн газраас ажлын байрыг нэмэгдүүлэх, дотоодын тээвэрчдийг дэмжих зорилгоор нүүрсний тээвэрлэлтэд зөвхөн Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгжийн, монгол дугаартай автомашин, жолоочийг ажиллуулж байна. Өнөөдрийн байдлаар 223 аж ахуйн нэгж 16767 тээврийн хэрэгслээр /14500 жолооч/ Тавантолгойн уурхайгаас Гашуунсухайт боомтоор нүүрсний тээвэрлэлт гүйцэтгэж байгаа бөгөөд эдгээр аж ахуйн нэгж, тээврийн хэрэгсэл, жолооч нь бүгд Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгжууд байна.

Үүнтэй холбоотой БНХАУ-ын зүгээс нүүрсний тээвэрлэлт БНХАУ-д бүртгэлтэй аж ахуйн нэгжийг ажиллуулж, Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах асуудлыг байнга тавьж байгаа хэдий ч өнөөдрийн байдлаар БНХАУ-д бүртгэлтэй нэг ч жолооч, тээврийн хэрэгслийг нүүрсний тээвэрлэлтэд ажиллуулахгүй байгаа болно. Нүүрс тээврийн аж ахуйн нэгжуудийн орлогын албан татвар төлөлтийг нэмэгдүүлэх үүднээс Сангийн сайд, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны 51/A/50 дугаар хамтарсан тушаалаар Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.

**Асуулга 3. Экспортын нүүрс тээвэрлэлтийн зөвшөөрлийн бичиг олголт, чингэлэг тээвэрлэлтийн тээврийн хэрэгслийн БНХАУ-ын талд бүртгүүлэх квотын асуудалд Монголын үндэсний тээвэрлэгчдийн орон зай, эрх ашгийг хамгаалах талаар Монгол Улсын Засгийн газраас ямар бодлого баримталж байгаа талаар;**

**Хариулт:** Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу жил бүр улс хоорондын ачаа, зорчигч тээвэрлэх зөвшөөрлийн бичгийн тоог тохирч, тохирсон тоогоор зөвшөөрлийн бичгийг бэлтгэн харилцан солилцдог бөгөөд эдгээр зөвшөөрлийн бичгийг БНХАУ-тай хиллэдэг хилийн бүх боомтуудад ашигладаг. БНХАУ-ын зүгээс Ганц мод боомтын нэвтрүүлэх хүчин чадалд тохируулан "С" терлийн зөвшөөрлийн бичгийг 6000-аас дээшгүй тээврийн хэрэгслэлд олгох шаардлагыг тавьж байна.

Үүнтэй холбоотойгоор аж ахуйн нэгжуудийн шинээр худалдан авсан тээврийн хэрэгслүүдийг БНХАУ-ын Ганц мод боомтын гаалийн байгууллага бүртгэх ажил удаашралтай байгаа хэдий ч тээврийн хэрэгслийг огт бүртгэхгүй байгаа асуудал байхгүй байна. Аж ахуйн нэгжуудийн шинээр худалдан авсан тээврийн хэрэгслүүдийг БНХАУ-ын ӨМӨЗО-ны гаалийн байгууллага шуурхай бүртгэж байх асуудлыг хятадын

талтай хийж буй уулзалтуудаар хятадын талд тавьж, холбогдох шийдвэрийг гарган ажиллаж байна.

Нүүрсний тээвэрлэлт гүйцэтгэж буй бүх аж ахуйн нэгж нь Монгол Улсад бүртгэлтэй, татвар төлөгч аж ахуйн нэгжүүд бөгөөд эдгээр аж ахуйн нэгжүүдийн тээвэрлэлтийн үйл ажиллагааг хумих, зогсоо тохиолдолд олон жолооч нар ажилгүй сүл зогсох эрсдэлтэй тул Монгол Улсад бүртгэлтэй татвар төлөгч аж ахуйн нэгжүүдийг ялгаварлан тээвэрлэлтэд оролцуулах боломжгүй юм.

2020 оны 11 дүгээр сард Монгол Улсын Зам, тээврийн хөгжлийн сайд, Сангийн сайдын хамтарсан тушаалаар Зам, тээврийн хөгжлийн Дэд сайдаар ахлуулсан Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж, Засгийн газар хоорондын автотээврийн хэлэлцээрийн дагуу олгож буй "С" терлийн зөвшөөрлийн бичгийн олголтыг татвар, нийгмийн даатгалын мэдээллийн сантай холбох ажлыг хийсэн. Үүний дунд нүүрс тээврийн компаниудын татвар төлөлт нэмэгдэж, гадаадын хөренгө оруулалттай олон автомашинтай компаниудын орлогын албан татвар төлөлтийг хугацаанд нь төлүүлж, татвар төлөлтийг харгалзан үзэж тээвэрлэлт хийх зөвшөөрлийн бичгийг олгож байна.

**Асуулга 4. Засгийн газраас "Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын хөтөлбөр" зарласан. Тус хөтөлбөрийн хүрээнд экспортын нүүрс тээвэрлэлтийн үндэсний компаниудад дэмжлэг үзүүлэх замаар тээвэрлэлтээс олох үр ашгийн дийлэнх хувийг эх орондоо үлдээх талаар төлөвлөгөө байгаа эсэх талаар**

**Хариулт:** Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 (арван) их наядын цогц төлөвлөгөөний 2.1-д ажлын байрыг дэмжих жилийн 3 хувийн хүүтэй, 3 жилийн хугацаатай 2.0 их наяд төгрөг хүртэл зээлийг олгохоор тусгасан. Ажлын байрыг дэмжих хүрээнд аж ахуйн нэгж, байгууллагад олгох зээл 500.0 сая төгрөг хүртэл хэмжээтэй байх ба Экспортын нүүрс тээвэрлэлтийн үндэсний компаниуд дээрх хөнгөлөлттэй зээлд хамрагдах бүрэн боломжтой байна.

**Асуулга 5. ЗГХЭГ-ын даргаар Л.Оюун-Эрдэнэ ажиллаж байх үед буюу Засгийн газрын 2019 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдаанаас "Тавантолгой Гашуунсухайт чиглэлийн нүүрс тээвэрлэлтэд үүсч байгаа хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэх тухай" гаргасан 01 тоот албан даалгавар огт биелэгдсэнгүй. Иймд Монгол Улсын нийт нүүрсний 65 хувийг дамжуулан гаргадаг, өдөрт 1100 орчим машин, олон зуун зорчигсдод үйлчилдэг "Гашуунсухайт" боомтод цахилгаан эрчим хүч, эмнэлэг болон төвлөрсөн засварын үйлчилгээ зэрэг суурьшлын бус байгуулах, экспортын нүүрс тээвэрлэх автозам, дэд бүтцийг сайжруулах талаар Засгийн газраас бодитойгоор ямар арга хэмжээ авахаар төлөвлөж байгаа талаар:**

**Хариулт:** 2019 онд батлагдсан "Тавантолгой-Гашуусухайт чиглэлийн нүүрс тээвэрлэлтэд үүсч байгаа хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэх тухай" Засгийн газрын 01 дүгээр албан даалгаврын хүрээнд нүүрсний тээвэрлэлтэд ажиллаж буй жолооч нарын ажиллах орчинг сайжруулах чиглэлээр дараах ажлууд хийгдсэн. Үүнд:

- Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт "Тээвэрчдийн хотхон" цогцолбор, Ханбогд сумын нутагт "Тайван

зогсоол" үйлчилгээний байгууламж баригдаж, эхнээсээ ашиглалтад орсон. Эдгээр үйлчилгээний цогцолборыг түшиглэн эрүүл мэндийн үйлчилгээний цэгийг ажиллуулах, тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээ, техникийн хяналтын үзлэгийн төв байгуулахаар холбогдох байгууллагууд ажиллаж байна.

- "Гашуунсухайт авто зам" ХХК-ийн бүтцэд Тавантолгой уурхай-Гашуунсухайт боомт чиглэлийн авто замын засварын ажлыг хариуцах нэгжийг байгуулж, зам засварын ажлыг хийлгэж байна. Мөн уг авто замын дагуу 15-20 км тутам тээврийн хэрэгсэл түр зогсох зогсоол, бие засах газар, хогийн цэгийг байгуулсан.

Авто замын тухайд: Монгол Улсын Засгийн газраас Тавантолгойн нүүрсний ордын үйл ажиллагаа эрчимжүүлэх,.govийн бусийн экосистемийг хамгаалах, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах, авто замын тээвэрлэлтийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор Тавантолгой-Гашуунсухайт чиглэлд одоо байгаа замтай зэрэгцүүлэн хүнд даацын хатуу хучилттай нэмэлт авто зам барихаар шийдвэрлэн, Засгийн газрын 2018 оны 329 дүгээр тогтоолын дагуу "Тал нутгийн хөгжлийн зам" ХХК-тай концессын гэрээ байгуулан, 2020 оны 6 дугаар сарын 28-ны өдрөөс зам барилгын ажлыг эхлүүлэн, одоогоор нийт зам барилгын ажлын 25 хувийг хийж гүйцэтгээд байна.

Хэдийгээр 2020 онд дэлхий нийтийг хамарсан КОВИД-19 цар тахлын хүчин зүйлээс шалтгаалан зам барилгын ажилд саатал гарсан хэдий ч гүйцэтгэгчийн зүгээс гэрээт хугацаандаа буюу 2022 онд багтаан ашиглалтад оруулахаар төлөвлөн, зам барилгын ажлын талбайд 800 гаруй хүн хүч, 300 гаруй техник, тоног төхөөрөмж байршуулан ажиллаж байна.

Энэхүү авто зам баригдсанаар нүүрсний экспортын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, тээвэр ашиглалтын зардлыг багасгах, улс орны эдийн засгийн ёсөлтийг дэмжих, орон нутагт ядуурлын түвшинг бууруулах, ажлын байр нэмэгдүүлэх зэргээр улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд чухал нөлөө үзүүлэхээс гадна ачаатай болон ачаагүй тээврийн хэрэгслүүдийн урсгал тусгаарлагдсанаар тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал сайжирч, зам, тээврийн осол эрс буурах юм.

Түүнчлэн, Засгийн газраас хэрэгжүүлж байгаа Гаалийн шинэчлэлийн хүрээнд Гашуунсухайт боомтод эрдэс баялгийн экспортын бус, зорчигч тээвэр, ачаа тээврийн бусийг байгуулж боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг З дахин нэмэгдүүлэх бөгөөд олон улсад итгэмжлэгдсэн гаалийн лабораторийг байгуулан, тээврийн хэрэгслийг автоматаар бүртгэх ухаалаг гарцууд, өндөр хүчин чадлын дээж авагч, рентген тоног төхөөрөмжүүдийг суурилуулахаар ажиллаж байна.

**Асуулга 6. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн бүтээн байгуулалтын ажлын явц хэдэн хувьтай хэрэгжиж байгаа болон инженерийн нарийвчилсан зураг төсөл, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, төмөр замын цариг, хил холболтын цэг, санхүүжилт зэрэг асуудлыг Засгийн газар хэрхэн шийдвэрлэж байгаа талаарх мэдээлэл зэрэг болно.**

**Хариулт:** Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 242, Засгийн газрын 2019 оны 304 дүгээр тогтоолын хэрэгжилтийг тус тус хангах ажлын хүрээнд "Тавантолгой төмөр зам" ХХК нь Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийн

Захиалагчаар, төслийн зураг төсөл, худалдан авалт, барилгын ажлын Ерөнхий гүйцэтгэгчээр "Бодь Интернэшнл" ХХК ажиллаж байна.

"Төреөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2014 оны 64 дүгээр тогтоолоор Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг 1520 мм царигтайгаар, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замыг 1435 мм царигтайгаар барьж байгуулахаар шийдвэрлэсэн байсныг Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 57 дугаар тогтоолоор 2014 оны "Төреөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай" 64 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсоноор тус чиглэлийн төмөр зам 1520 мм царигтайгаар баригдахаар болсон.

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийн өргөн царигийн /1520мм/ ТЭЗҮ-ийн судалгааг Австрали улсын АЕКОМ компани 2013 онд хийсэн. 2020 онд БНСУ-ын "Дон Мёнг Инженеринг энд Консалтэнтс" компани нь "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн захиалгаар тус чиглэлийн төмөр замын төслийн ТЭЗҮ-ийн судалгааны тодотголыг гүйцэтгэж, төмөр замын шугамын чигийн холбогдох тооцоо, судалгааг шинэчлэн боловсруулсан. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг анх 2012 онд "Монголын төмөр зам" ТӨХК захиалан гүйцэтгүүлсэнийг "Тавантолгой төмөр зам" ХХК 2020 онд "Газар-Лха" ХХК-иар тодотгол хийлгэсэн. Төмөр замын чигийн дагуу нийт 16 гүүр, 12 ширхэг мал амьтны нүхэн гарц, 160 ширхэг ус өнгөрүүлэх хоолой төлөвлөсөн.

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн бүтээн байгуулалтын ажлын явц 2021 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн байдлаар дараах явцтай байна. Үүнд:

- Газар шорооны ажил:

- Гол замын 207км шугамын хувьд шинээр гүйцэтгэх 3.76 сая м3 газар шорооны ажил 79.8%;
- Тавантолгой өртөөний зам паркийн 0.25 сая м3 газар шорооны ажил – 100%;
- Тавантолгой уурхайн ачилтын тойргийн 0.81 сая м3 газар шорооны ажил – 100%;
- Хил холболтын хэсгийн 30.9км орчим төмөр замын шугамын 3.7 сая м3 газар шорооны ажил - 97.06% -ийн тус тус гүйцэтгэлтэй байна.

- Шинээр нийт 16 гүүр барих ажил дунджаар 71.27%-ийн гүйцэтгэлтэй.

- Төслийн хүрээнд 2 өртөө, 6 зөрлөг барихаас Тавантолгой өртөө 31.4%, I зөрлөг 32.6%, II зөрлөг 37.1%, III зөрлөг 43.0%, IV зөрлөг 0.3%, V зөрлөг 26.5%, VI зөрлөг 28.2%-ийн тус тус гүйцэтгэлтэй.

- Төмөр замын гол замын дээд бүтцийн үе угсралт 199.65км-т гүйцэтгэгдсэн,

- Дохиолол, төвлөрүүлэлт, хориглолын байгууламжийн зураг төсөл, худалдан авалт, угсралт, суурилалтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан бөгөөд ажлын зураг хийгдэж байна. Эрчим хүчний угсралт, суурилалтын ажил 2.9%-ийн гүйцэтгэлтэй.

Төслийн барилгын ажлыг төлөвлөгөөний дагуу 2022 оны 07 дугаар сард дуусгахаар ажиллаж байна.

**Хилийн холбох цэгийн хувьд:** Гадаад харилцааны сайд, Зам тээврийн хөгжлийн сайдын хамтарсан тушаалаар байгуулсан Ажлын хэсэг батлагдсан удирдамжийн дагуу

хятадын талтай Монгол, Хятадын Гашуунсухайт-Ганц мод төмөр замын боомтын хилийн төмөр замын улсын хилийн шугам дайран өнгөрөх цэгийг тохиролцох зорилгоор 2021 оны 03 дугаар сарын 28-31-ний өдрүүдэд тус боомтод томилолтоор ажиллаж, хятадын талтай өргөн хүрээнд санал солилцож, санамж бичиг байгуулсан. Цаашид талуудын төмөр замын суурь бүтэц зээмшигч байгууллагууд харилцах, хилийн төмөр замын техникийн нөхцөлийг тохиролцсоны дараа дипломат шугамаар хил нэвтрэх цэгийг эцслэн тохиролцоо болсон.

-----оОо-----